# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

## 2019 оны дөрөвдүгээр сарын байдлаар




ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ– Төсөв

## төсвийн орлого, зарлага / сая төгрөг /

| | 2018 I-IV | 2019 I-IV |
|---|---|---|
| орлого | 14 193.9 | 15 206.0 |
| зарлага | 11 495.3 | 13 394.2 |

## төсвийн орлогод эзлэх хувь 2019 оны 4 сарын байдлаар



# ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ– Банк

## МОНГОЛ БАНК МЭДЭЭ / сая төгрөг /

| 2018 I-IV | | 2019 I-IV |
| --- | --- | --- |
| 49 810.0 | НИЙТ ХАДГАЛАМЖ | 61 412.7 |
| 95 467.1 | ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ | 111 645.4 |

Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 16.9 хувиар өсч 111645.4 сая төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 739.8 сая төгрөг, чанаргүй зээл 1085.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 1.5 хувиар , чанаргүй зээл 25.7 хувиар тус тус өссөн байна.

# ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – АЖ ҮЙЛДВЭР

## АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ /САЯ.ТӨГ/




**Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2019 оны 4 сарын байдлаар 3849.8 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 18.9 хувиар өссөн байна**

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд

## Эмнэлэгт эмчлэгдэж гарсан хүний тоо, амбулаторийн үзлэгийн тоо



| | 2017 I-IV | 2018 I-IV | 2019 I-IV |
|---|---|---|---|
| Эмчлэгдэн гарсан хүний тоо | 3740 | 4178 | 3958 |
| Амбулаторийн үзлэгийн тоо | 29426 | 57573 | 59371 |

Тухайн сарын байдлаар стационарит шинээр 3980 эмчлүүлэгч хэвтэж, 3958 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 29469 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.4 байна. 2019 оны 4 сарын байдлаар 59371 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 27.1 %, амбулаторийн үзлэг 49.2 %, идэвхтэй хяналт 15.4 %, гэрийн үзлэг 5.9 %- ийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 35.7 хувь нь эрэгтэй, 64.3 хувь нь эмэгтэй хүн байна.

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд

| | Амаржсан эхийн тоо | Амьд төрсөн хүүхдийн тоо | 0-1 насны хүүхдийн эндэгдэл | 1-5 насны хүүхдийн эндэгдэл |
|---|---|---|---|---|
| 2017 I-IV | 279 | 280 | 3 | 1 |
| 2018 I-IV | 305 | 306 | 2 | 4 |
| 2019 I-IV | 292 | 293 | 0 | 0 |

Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2019 оны 4-р сарын байдлаар 292 эх төрсөн ба нийт 293 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 13 тохиолдолоор буурсан байна. Төрсөн эхчүүдийн 91.8 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт энэ сарын байдлаар эхийн эндэгдэл болон 0-5 хүртлэх насны хүүхдийн эндэгдэл гараагүй.

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд

## Бүртгэгдсэн халдварт өвчлөлийн тоо




Халдварт өвчний  142 тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн үеэс 23 тохиолдлоор буурч, 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 30.5 болж өмнөх оны мөн үеэс 5.5 пунктээр буурсан байна.

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Хөдөлмөр

## АЖИЛ ХАЙГЧ ИРГЭН, жил бүрийн 4 сарын байдлаар




| | 2017 I-IV | 2018 I-IV | 2019 I-IV |
|---|---|---|---|
| Ажил хайгч иргэн | 814 | 642 | 360 |
| Үүнээс эмэгтэй | 424 | 326 | 165 |

2019 оны 4 сарын байдлаар аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй, ажил хайж байгаа 360 хүн бүртгэгдсэн нь өмнөх сараас 130 хүнээр буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 45.8 хувь буюу 165 хүн нь эмэгтэйчүүд байна.

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Хөдөлмөр

**Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүйчүүд, 2019 оны эхний 4 сарын байдлаар, сумаар**






**аймгийн хэмжээнд 118**

**Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 118 ажил хайгч иргэн ногдож байхад Говь-Угтаал 539, Луус 279, Гурвансайхан 191, Баянжаргалан 250, Цагаандэлгэр 145, Адаацаг 153 байгаа нь аймгийн дунджаас дээгүүр байна..**

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Хөдөлмөр

## НИЙГМИЙН ХАЛАМЖИД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО
## 2019 оны 4 сарын байдлаар

**ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР**
745 ИРГЭН

**ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ**
1469 ИРГЭН

**АЛДАРТ ЭХИЙН ОДОН**
4371 ИРГЭН

**НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**
1 117 ИРГЭН

**ОЛОН ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ, ЭЦЭГ**
3153 ИРГЭН

**НАСНЫ ХИШИГ**
2 392 ИРГЭН

**БУСАД**
303 ИРГЭН

2019 оны эхний 3 сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас 13168 хүнд 1999.2 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, халамжийг олгосон байна

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Гэмт хэрэг

## БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧДЫН ТОО, жил бүрийн 4 сарын байдлаар




Цагдаагийн хэлтсийн 2019 оны 4 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 88 болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13.7 хувь болж буурсан байна. Гэмт хэрэгт холбогдогчдын тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 52 хувиар өгч 38 хүн холбогдоод байна.

# ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хэрэглээний үнэ

## Дундговь аймгийн хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 сар =100)




**Тус аймагт 2019 оны 4 сарын байдлаар өмнөх оны 12 сартай харьцуулахад хэрэглээний үнийн индекс 3.1 хувиар өсжээ. Хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 10.9 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 4.6 хувиар, хувцас бөс бараа гутал 1,7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 3,4 хувиар өссөн нь нөлөөлсөн, эм тариа эмчилгээний бүлэг хэвээр байна**

# ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хэрэглээний үнэ

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, /ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛСАНААР/




**Тус аймагт 2019 оны 4 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэрэглээний үнийн индекс 5,6 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 10,5 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 8,0 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлэг 6.2 хувь өссөн, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг 0,1 хувиар өссөн, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 6,9 хувь, эм тариа эмчилгээний бүлэг 9,3, тээврийн бүлэг 4,9 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.**

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Статистик

Мэдээ, мэдээлэл

Номын сан

Мэдлэгээ шалгах тоглоом

Валютын ханш




**1212.mn** аппликейшнаас

# СТАТИСТИКИЙН

мэдээллээ аваарай

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН